

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалын код: 65.020.40

Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага	MNS 5994 : 2009
Seeds of trees and shrubs. Sowing characteristics. Specifications	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдөнө. Энэхүү стандартын шаардлагыг заавал¹ мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь тариалах зориулалтаар бэлтгэсэн болон экспорт, импортын бүх төрлийн мод, сөөгний үрийн зэрэг дугаарыг тогтоох, шалгаж хүлээн авах, савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- a) Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн нөхцөл ГОСТ 13857-95
- b) Шилмүүст модны үр. Тариалалтын чанар. Техникийн нөхцөл ГОСТ 14161-86
- c) Яст болон үрт үр жимст модны үр. Тариалалтын чанар. Техникийн нөхцөл ГОСТ 13853-78

3 Ангилал

3.1 Мод, сөөгний үрийн соёололт, амьдрах чадвар, цэвэршилт гэсэн үзүүлэлтүүдийг үндэслэн үрийг тариалалтын чанараар ангилна:

- Нэгдүгээр зэрэг,
- Хоёрдугаар зэрэг,
- Гуравдугаар зэрэг.

3.2 Дээрх үзүүлэлтүүдээр стандартын шаардлага хангахгүй байгаа үрийг стандартын бус үр гэнэ.

4 Техникийн шаардлага

4.1 Мод, сөөгний тарих үрийг ойн үрийн хэсэг, плантац, үрийн мод, удамшлын хувьд хэвийн болон сайн чанарын ой, модноос бэлтгэнэ.

¹ Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 38 дугаар тогтоолоор эрх зүйн хэм хэмжээг “сонгон хэрэглэх” болгон өөрчлөв

MNS 5994 : 2009

4.2 Мод, сөөгний үрийг боргоцойн хайрс, навч, шилмүүс, үр жимсний хальс, модны холтос, өвс, бусад хольцоос сайн цэвэрлэсэн, бүрэн гүйцэд боловсорсон байна.

4.3 Тарих үрийг лабораторийн шинжилгээний дүгнэлтгүйгээр худалдах, худалдан авах, тариалалтад хэрэглэхийг хориглоно.

4.4 Мод, сөөгний үр нь 1-р хүснэгтэд заасан үзүүлэлтүүдийг хангасан байна:

1-р хүснэгт

д/д	Үүзүүлэлтийн нэр	Шинж чанар
1	Биет байдал	Үр нь гүйцэд боловсорсон, үр жимс, боргоцойноос нь салгаж цэвэрлэсэн, бяцарч гэмтээгүй байна.
2	Өнгө	Үрийн өнгө өөрчлөгдөж хувираагүй, байгалийн өнгө нь хэвээр байна.
3	Үнэр	Тухайн ургамлын үр жимсний үнэртэй, гадны ямар нэг үнэргүй байна.

4.4 Мод, сөөгний үрийн цэвэршилт, соёололт, амьдрах чадвар 1000 үрийн жин, үрийн чийг, өвчин хортонд гэмтсэн байдлыг стандартын дагуу ойн үрийн лабораторид тодорхойлно.

4.5 Мод, сөөгний тарих үрийг тариалалтын чанараар нь 2-р хүснэгтэд заасны дагуу гурван зэрэгт хуваана.

Мод, сөөгний үрийн чанарын зэрэг

2-р хүснэгт

д/д	Мод сөөгний нэр /үрийн нэр/ (Монгол, орос, латин нэр)	Зэргийн ангилал	Соёололт, % багагүй	Амьдрах чадвар, % (багагүй)	Цэвэршилт % (багагүй)
1	Шар хуайс Жёлтая акация <i>Caragana arberescens</i> Lam.	1	90	-	94
		2	75	-	
		3	55	-	
2	Яшилдуу чацаргана Облепиха крушиновая <i>Hippophae rhamnoides</i> L.	1	90	-	94
		2	75	-	
		3	60	-	
3	Сибирийн гандигар Бузина сибирская <i>Sambucus sibirica</i> . Nakai	1	-	90	95
		2	-	65	
		3	-	50	
4	Алтайн далан хальс Жимолость алтайская <i>Lonicera altaica</i> . Pall.	1	-	90	93
		2	-	85	
		3	-	60	
5	Хар үрт чаргай Кизильник чёрноплодный <i>Cotoneaster melonocarpa</i> L.	1	-	90	95
		2	-	75	
		3	-	60	
6	Сибирийн тэс Рябина сибирская <i>Sorbus sibirica</i> Hedl	1	-	90	90
		2	-	85	
		3	-	55	
7	Үхрийн нүд Смородина чёрная <i>Ribes nigrum</i> L.	1	-	95	95
		2	-	80	
		3	-	60	
8	Палласын өрөл Яблоня Палласа <i>Malus Pallasiana</i> Juz.	1	-	90	93
		2	-	80	
		3	-	65	
9	Явган хайлаас Вяз приземистый	1	65	-	61
		2	55	-	

	<i>Ulmus pumilla</i> L.	3	40	-	
10	Хавтага навчит хус	1	55	-	25
	Береза плосколистная	2	35	-	
	<i>Betula platyphylla</i> . Sukacz	3	25	-	
11	Зайсангийн заг	1	70	-	55
	Саксаул Зайсанский	2	60	-	
	<i>Haloxylon ammodendron</i>	3	50	-	
12	Сибирийн гацуур	1	80	80	90
	Ель Сибирская	2	65	65	
	<i>Picea obovata</i> Ldb	3	50	50	
13	Дагуур ^{ын} шинэс	1	50	50	86
	Лиственница Даурская	2	35	35	
	<i>Larix Dahurica</i> Turcz	3	25	25	
14	Сибирийн шинэс	1	70	70	93
	Лиственица сибирская	2	55	55	
	<i>Larix sibirica</i> Ldb.	3	40	40	
15	Сибирийн хуш	1	-	85	96
	Кедр сибирский	2	-	70	
	<i>Pinus sibirica</i> Mayr.	3	-	50	
16	Эгэл нарс	1	90	90	92
	Сосна обыкновенная	2	80	80	
	<i>Pinus silvestris</i> L.	3	60	60	
17	Сибирийн гүйлс	1	-	95	99
	Абрикос сибирский	2	-	90	
	<i>Armenica sibirica</i> Lam.	3	-	80	
18	Час улаан долоогоно	1	-	85	96
	Боярышник крававо-красный	2	-	70	
	<i>Crataegus sanguinea</i> Pall	3	-	55	
19	Жигд	1	95	-	94
	Лох	2	85	-	
	<i>Elaeagnus moorcroftii</i>	3	60	-	
20	Нохойн хошуу	1	-	85	95
	Шиповник иглистый	2	-	65	
	<i>Rosa acicularis</i> Lindl	3	-	50	
21	Азийн монос	1	-	90	94
	Черемуха азиатская	2	-	70	
	<i>Radus asiatica</i> Mill	3	-	60	
22	Сибирийн жодоо	1	40	40	80
	Пихта сибирская	2	25	25	
	<i>Abies sibirica</i> Ledeb	3	10	10	
23	Хурц навчит агч	1	85	-	85
	Клён остролистный	2	75	-	
	<i>Acer platanooides</i> L	3	60	-	
24	Голт бор	1	85	-	85
	Сирень обыкновенная	2	75	-	
	<i>Syringa vulgaris</i> L.	3	60	-	
25	Бүйлс	1	95		98
	Миндаль обыкновенный	2	80		
	<i>Amygdalus communis</i> L	3	55		

4.6 Мод, сөөгний үр нь паразит болон паразит бус мөөгөнцрөөр бохирдсон байвал тариалахын өмнө болон тарилтад бэлтгэж эртжүүлэхийн өмнө ариутгасан байна

5 Дээж авах

5.1 Мод, сөөгний хэсэг үрийг бүрдүүлсний дараа уг үрэнд MNS 2429:2009 стандартын дагуу паспорт хөтөлж, хаяглана.

5.2 Мод, сөөгний хэсэг үр бүрээс MNS 2429:2009 стандартын дагуу дээж авч ойн үрийн лабораторид илгээнэ.

6 Савлалт, хаяглалт

Мод, сөөгний үр хийсэн савны гадна талд хаяг /шошго/ нааж, MNS 2429:2009-ийн дагуу хаяглана. Мөн савны дотор үрийн хаягийн хуулбарыг хийнэ.

7 Хадгалах

7.1 Шинэ түүсэн мод, сөөгний үрийг хуурай, агааржуулалт сайтай байранд эсвэл задгай талбайд сүүдэр газар 15 см-ээс ихгүй зузаантай үеэр тараан байнга хутгаж хатаана.

7.2 Мод, сөөгний үрийг хортон шавж, мэрэгчдээс хамгаалсан тусгай зориулалтын агуулах, саванд хадгална.

7.3 Үрийг хадгалах агуулахын агаарын харьцангуй чийг 60-аас 70 % байна.

7.4 Хадгалалтад байгаа мод, сөөгний үр нь 3-р хүснэгтэд заасан чийгтэй байна.

Хадгалах үрийн чийгийн хэмжээ
3-р хүснэгт

д/д	Үрийн нэр	Чийг, %	д/д	Үрийн нэр	Чийг, %
1	Гацуур	6,5-7	12	Өрөл	10
2	Жодоо	11-13	13	Гүйлс	11
3	Шинэс	8-9	14	Чаргай	12
4	Нарс	6-7,5	15	Монос	10-12
5	Хуш	11	16	Нохойн хошуу	8-10
6	Шар хуайс	11-12	17	Жигд	10-12
7	Далан хальс	8-10	18	Агч	10-12
8	Тэс	9-10	19	Голт бор	7-9
9	Хус	7-8	20	Гандигар	8-10
10	Заг	6-7	21	Долоогоно	10-12
11	Чацаргана	10-14	22	Хайлаас	7-8

7.5 Шилмүүст модны үрийг (хушнаас бусад) шилэн сав, зэвэрдэггүй метал саванд хийж битүү таглан, харин хушны үрийг хайрцаганд 100 см-ээс илүүгүй зузаантайгаар эсвэл даавуун уут шуудайд хийж тавиур дээр эгнүүлэн тавьж хадгална.

7.6 Хусны үрийг хуурай модон хайрцагт цаас дэвсэж 4 см хүртэл зузаантайгаар үелүүлэн хийж үеүдийн хооронд цаасаар тусгаарлана. Мөн даавуун уутанд хийж хананаас хөндий өлгөж хадгална. Яст үрийг цэвэр шуудайд, буурцагт үрийг цаасан уут, хайрцагт хадгална.

7.7 Шилмүүст модны 1-р ба 2-р зэргийн үрийг битүү таглаатай шилэн саванд хийж лацдаж битүүмжлэн 4-өөс 5 жил хадгалж болно. Хус, агч, түүнчлэн навчит мод, сөөгний 3-р зэргийн үрийг 1 жил, бусад үрийг 2 жил хүртэл хугацаагаар хадгалж

болно. Хайлаас, улиасны үрийг хадгалахгүйгээр түүж бэлтгээд шууд тарина. Загийн үрийг үр бэлтгэсний дараах анхны хавар хүртэл хадгалж болно.

7.8 Савласан үрийг шалнаас дээш 20-оос 30 см өндөр тавиур дээр нарны гэрлийн шууд тусгалаас хол, хананаас 0,5 м-ээс багагүй зайд дан үеэр эгнүүлэн тавина. Тавиур нь олон давхар үетэй байж болно. Харин шуудайд хийсэн үрийг хана, таазанд хүргэлгүй хөндий дүүжилнэ.

8 Тээвэрлэлт

8.1 Битүүмжлэл сайтай болон цас борооноос хамгаалж бүтээсэн, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан бүх төрлийн тээврийн хэрэгслэлээр тээвэрлэнэ.

8.2 Тээвэрлэх үрийн савтай жин 50 кг-аас ихгүй байна

8.3 Шилэн савтай үрийг тээвэрлэх тохиолдолд хагарч гэмтэхээс хамгаалсан тусгай зөөлөвч, хайрцагт хийсэн байна.

9 Шалгаж хүлээн авах

9.1 Мод, сөөгний үр нь ойн үрийн лабораториас олгосон шинжилгээний дүгнэлттэй болон үрийн паспорт, үрийн хаягт заасан үзүүлэлтүүд тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, хүлээн авна.

9.2 Үрийн савны гаднах хаяг унаж гээгдсэн тохиолдолд саван доторх хаягтай тулган шалгаж, гадна талд нь дахин хаяг наана.

ТӨГСӨВ.